ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ ХХК

АЛТАН САН АКТИВ ББСБ ХХК-ИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот 2022 он	**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:** “Лидер экаунт аудит” ХХК Утас: 88112654, 88472789 Цахим хаяг: leaderaudit.20@gmail.com

“ЛИДЕР ЭКАУНТ АУДИТ” ХХК

2023 оны 2 сарын 09 өдөр

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо,
Төмөрчний гудамж - 8, 405 тоот
Утас: +976 7711-4519, 88472789, 88112654
И-мэйл: leaderaudit.20@gmail.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

АЛТАН САН АКТИВ ББСБ ХХК-ИЙН УДИРДЛАГАД

Дүгнэлт

Бид Алтан сан актив ББСБ ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Алтан сан актив ББСБ ХХК 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал болон уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын сандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Аудитын явцад бидний олж авсан баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг, хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АДБОУС)-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулагад санал өгөх хангалттай зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг менежентийн захидалд тусгасан болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Алтан сан актив ББСБ ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Лидер экаунт аудит ХХК
Захирал П.Шаравхорол
2023 оны 02 сарын 09

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АЛТАН САН АКТИВ ББСБ ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТОДРУУЛГА	2021 ОНЫ 12-Р САРЫН 31	2022 ОНЫ 12-Р САРЫН 31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрнгө	3.1	147,428,968.21	84,129,593.19
Зээл/Цэвэр/	3.2	2,749,427,282.40	2,895,906,513.95
Бусад авлага	3.3	780,124,325.16	844,787,365.04
Бусад хөрөнгө	3.4	100,000,000.00	100,000,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн		**3,776,980,575.77**	**3,924,823,472.18**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	3.5	-	-
Биет бус хөрөнгө		-	-
Эргэлтийн бус хөрнгө		-	-
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**3,776,980,575.77**	**3,924,823,472.18**
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Бусад өр төлбөр	3.6	10,403,395.41	11,673,638.61
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**10,403,395.41**	**11,673,638.61**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		**10,403,395.41**	**11,673,638.61**
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувьцаат капиталын дүн	3.7	1,854,000,000.00	1,908,000,000.00
Хуримтлагдсан үр дүн		**1,912,577,180.38**	**2,005,149,833.57**
Өмнөх үеийн үр дүн		105,984,232.55	152,572,653.19
Тайлант үеийн үр дүн		1,806,592,947.83	1,852,577,180.38
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		**3,766,577,180.38**	**3,913,149,833.57**
НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨМЧИЙН ДҮН		**3,776,980,575.79**	**3,924,823,472.18**

2.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан

АЛТАН САН АКТИВ ББСБ ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ХҮҮГИЙН ОРЛОГО		**337,983,436.80**	**370,404,577.14**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	3.8	337,819,049.50	368,082,287.68
Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого		128,080.68	2,322,289.46
Харилцах дансны хүүгийн орлого		36,306.62	-
Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого		**337,983,436.80**	**370,404,577.14**
ХҮҮГИЙН БУС ОРЛОГО		-	-
Гадаад валютын арилжааны орлого		-	-
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого		-	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого		-	-
Бусад үйлчилгээ		-	-
ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	3.9	**113,303,806.45**	**137,041,631.76**
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал		-	-
Боловсон хүчний холбогдолтой зардал		79,072,850.45	99,700,902.78
Бусад зардал		34,230,956.00	37,340,728.98
ЦЭВЭР ХҮҮГИЙН БУС ОРЛОГО/ЗАРДЛЫН ДҮН		**(113,303,806.45)**	**(137,041,631.76)**
БОЛЗОШГҮЙ ЭРСДЛИЙН САН БАЙГУУЛАХААС ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**224,679,630.35**	**233,362,945.38**
Эрсдлийн зардал		106,814,891.96	79,249,154.26
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ		**117,864,738.39**	**154,113,791.12**
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3.10	104,480.00	-
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ		**117,760,258.39**	**154,113,791.12**
Орлогын татварын зардал	3.11	11,776,025.84	1,541,137.91
ЦЭВЭР АШИГ		**105,984,232.55**	**152,572,653.21**

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

АЛТАН САН АКТИВ ББСБ ХХК-ИЙН
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	**1,854,000,000.00**	**1,806,592,948.00**	**3,660,592,948.00**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	1,854,000,000.00	**1,806,592,948.00**	**3,660,592,948.00**
Тайлант үеийн үр дүн		105,984,233.00	**105,984,233.00**
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,854,000,000.00**	**1,912,577,180.00**	**3,766,577,180.00**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл	-	-	-
Ногдол ашиг		(60,000,000.00)	**(60,000,000.00)**
Хувьцаат капиталын өсөлт	54,000,000.00		**54,000,000.00**
Тайлант үеийн үр дүн		152,572,653.00	**152,572,653.00**
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,908,000,000.00**	**2,005,149,834.00**	**3,913,149,834.00**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АЛТАН САН АКТИВ ББСБ ХХК-ИЙН

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 НЭЭРХ)

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	**117,263,352.92**	**156,130,390.30**
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	**237,058,253.37**	**300,843,791.43**
Зээлийн хүүгийн орлого	237,021,946.75	300,843,791.43
Харилцах дансны хүүгийн орлого	36,306.62	-
Гадаад валютын ханшийн зөрүү	-	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	-	-
Бусад үйлчилгээний орлого	-	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	**119,794,900.45**	**144,713,401.13**
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал	-	-
Үндсэн ба нэмэгдэл цалин	55,480,991.45	58,673,014.00
Ажилтануудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	122,480.00	-
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	15,979,330.93	21,363,105.04
Албан томилолт, сургалтын зардал	-	108,000.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	729,000.00	729,300.00
Шатахуун, холбоо, интернэт, слбэг хэрэгсэлд төлсөн зардал	2,567,904.00	3,393,418.98
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	507,800.00	425,500.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	14,113,442.07	27,309,103.11
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	271,700.00	218,950.00
Санхүү түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарсан мөнгө	6,120,000.00	5,520,000.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	3,000,000.00	-
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	2,700,000.00	3,508,600.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	-
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	18,202,252.00	23,464,410.00
ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(270,437,545.02)**	**(219,429,765.32)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага	**270,437,545.02**	**219,429,765.32**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	-	-
Бусад	270,437,545.02	219,429,765.32
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(153,174,192.10)**	**63,299,375.02**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	300,603,160.31	147,428,968.21
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	147,428,968.21	84,129,593.19